Залруулсан үлдэгдэл	874,877,566.30	111,945,038,866.86	275,922,698,596.99	-178,006,147,630.25	210,738,467,399.90
Тайланг үеийн нэмэгдэл (алдагдал)				-27,189,373,028.94	-27,189,373,028.94
Өмчид гарсан өөрчлөлт				13,495,460,056.01	13,495,460,056.01
Зарласан ногдол ашг				-418,814,078.47	-418,814,078.47
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				-6,899,298.89	-6,899,298.89
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	874,877,566.30	111,938,139,567.97	289,418,158,653.00	-205,614,334,737.66	196,616,841,049.61
Нягтлан бодох бүртгэлтний бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				135,201,860.97	135,201,860.97
Залруулсан үлдэгдэл				-13,785,417,448.16	-13,785,417,448.16
Тайланг үеийн цэвэр ашг (алдагдал)				0.00	0.00
Өмчид өргөнгүй орлого				144,134,912,545.07	144,134,912,545.07
Зарласан ногдол ашг				290,252,762,742.25	290,252,762,742.25
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	874,877,566.30	111,938,139,567.97	435,536,008,850.18	-75,129,637,779.78	473,219,388,204.67

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйцээний тайлан

Мөрийн дугаар	Зүүллэлт	2020 оны 12-р сарын 31	Лөгрөгөөр/ 2021 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйцээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	71,176,747,126.84	66,794,178,837.29
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	68,226,239,162.36	64,676,791,243.58
	Даатгалын нөхөрөөс хүлээн авсан мөнгө	1,407,240.00	
	Татаас, санхүүжилтийн орлого	135,966,766.54	1,117,387,593.71
	Бусад мөнгөн орлого	2,812,134,967.94	
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	66,703,276,787.19	66,143,660,112.46
	Ажиллагаанд төлсөн	25,634,425,482.41	27,006,886,860.26
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	7,556,047,015.79	8,487,551,887.59
	Бараа материал худалдан авахад төлсөн	6,887,930,532.40	3,369,073,840.53
	Ашиглалтын зардалд төлсөн	13,849,355,099.98	14,260,759,830.22
	Тулш шатахуун, тээврийн хөлс, салбэг хэрэгсэлд төлсөн	2,936,253,636.16	2,832,320,206.20
	Хүүгийн төлбөрт төлсөн		
	Татаарын байгууллагад төлсөн	7,269,995,940.22	8,466,858,209.84
	Даатгалын төлбөрт төлсөн	109,940,050.99	41,369,800.00
	Бусад мөнгөн зарлага	2,659,428,009.84	4,678,739,437.82
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйцээний дүн	4,472,471,368.66	-3,349,381,276.17
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйцээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	8,896,737,335.57	5,980,456,825.05
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	8,754,013,405.57	5,639,549,523.05
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	142,723,930.00	340,906,302.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйцээний дүн	-8,896,737,335.57	-5,980,456,825.05
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйцээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,513,665.40	28,002.32
	Бусад	1,513,665.40	28,002.32
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	57,270.22	36,917.23
	Бусад	57,270.22	36,917.23
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйцээний дүн	1,456,395.18	-8,914.91
4	Валютын ханшийн зөрүү		
5	Бүх цэвэр мөнгөн гүйцээ	-4,422,809,591.74	-9,329,846,016.13
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	27,319,156,568.74	22,896,346,967.00
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	22,896,346,967.00	13,566,500,961.87

2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилгот төвшний гүйцэтгэл

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	/Мянган төгрөг/ Хувь
1	Нийт орлогын дүн	66,082,666.2	69,765,760.9	4,683,184.7	107.2
1.1	Цэвэр усны орлого	34,936,512.6	37,537,278.4	2,600,765.8	107.4
1.2	Бохир ус татан зайлуулсан орлого	27,628,881.7	29,647,862.0	1,818,980.3	108.5
1.3	Бусад орлого	2,317,171.9	2,580,610.6	263,438.7	111.4
2	Нийт зардал	89,136,021.3	84,265,285.1	(4,870,736.2)	94.5
2.1	Үндсэн ба нэмэгдэл цалин	31,896,818.0	31,739,831.8	(156,986.2)	99.5
2.2	Ажил олгогчоос эмзэглэлийн хуудсаар олгосон	53,032.1	123,598.8	70,566.7	233.1
2.3	НДШ, ЭМД	4,653,812.7	4,489,421.5	(164,391.2)	96.5
2.4	Хоол, унаа	1,705,720.5	1,617,727.6	(87,992.9)	94.8
2.5	Сургалт	91,642.0	34,765.3	(56,876.7)	37.9
2.6	Тэтгэмж болон нийгмийн арга хэмжээ	271,440.0	160,000.4	(111,439.6)	58.9
2.7	Шагнал	-	4,259.4	4,259.4	
2.8	Хярг, мөнгөний сульфат, бодис, давс	2,241,222.0	1,699,501.1	(541,720.9)	75.8
2.9	Сэлбэг, багаж хэрэгсэл	1,545,562.6	1,288,001.7	(257,560.9)	83.3
2.10	Хангамжийн зардал	126,332.1	99,273.3	(27,058.8)	78.6
2.11	Түлээ, нүүрс	48,344.5	47,174.3	(1,170.2)	97.6
2.12	Шатахуун, тосолгоо	2,199,442.4	2,301,725.8	102,283.4	104.7
2.13	Цахилгаан	12,936,182.1	12,326,998.3	(609,183.8)	95.3
2.14	Дулаан, СӨХ	368,113.8	295,976.3	(72,137.5)	80.4
2.15	Ус	48,090.2	35,167.0	(12,923.2)	73.1
2.16	Харуул, хамгаалт	269,172.8	246,157.0	(23,015.8)	91.4
2.17	Урсгал засвар, аваргааварын нөөц сан, тохижилт	1,533,009.5	1,003,256.9	(529,752.6)	65.4
2.18	Лайгн зардал	81,174.6	72,454.1	(8,720.5)	89.3
2.19	Бичиг хэрэг	84,666.6	60,404.2	(24,262.4)	71.3
2.20	Холбоо шуудан холбоо, хэвлэл захиалга	206,463.4	160,900.6	(45,562.8)	77.9
2.21	Томилголт	26,961.0	1,268.3	(25,692.7)	4.7
2.22	Зар сурталчилгаа, олон нийтийн зардал	145,750.0	148,032.7	2,282.7	101.6
2.23	Гаднын үйлчилгээ	94,216.8	61,024.7	(33,192.1)	64.8
2.24	Банкны үйлчилгээ	4,519.3	1,470.4	(3,048.9)	32.5
2.25	Хөдөлмөр хамгаалал	1,094,171.0	1,050,615.2	(43,555.8)	96.0
2.26	Лабораторийн зардал	195,042.0	103,766.0	(91,276.0)	53.2
2.27	Төслийн зардал	290,101.1	244,358.1	(45,743.0)	84.2
2.28	УЗ-ын зардал	43,686.0	42,692.9	(993.1)	97.7
2.29	Найдваргүй авлагын зардал	57,390.4	335,362.6	277,972.2	584.4
2.30	Татвар, хураамж	954,677.7	910,961.0	(43,716.7)	95.4
2.31	Даатгал	122,592.1	80,230.4	(42,361.7)	65.4
2.32	Зэвгийн хүү				
2.33	Элэгдэл	25,746,672.0	23,478,907.4	(2,267,764.6)	91.2
3	Үйл ажиллагааны алдагдал	(24,053,456.1)	(14,499,634.2)	9,553,821.9	60.3

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдч этгээдэд авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, үндсэн хөрөнгийг дахин үнэлээгүй зэрэг мэдээлэлтэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг НТАГ-ын аудитын хоёрдугаар хэлтсийн аудитор Н.Бадамхатан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Отгонбаяр, хэлтсийн дарга, аудитын менежер З.Мөнхбаяр, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Эрдэнэжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг НТАГ-т 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 4/174 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Дотоод хяналт

Тайлан хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар, түүний дотор дотоод аудиторын тайлант оны ажлын төлөвлөгөө, гүйцэтгэлийн талаар. Нийслэлийн Дотоод аудитын газраас дотоод аудитыг хэрэгжүүлдэг, тайлант онд шилэн дансны цахим мэдээлэлд дотоод аудит хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилто оршино.

4	Үйл ажиллагааны орлогын 1 төгрөгт ногдох зардал	1.37	1.21	(0.16)	88.2
5	Үйл ажиллагааны бус орлого	1,180,280.2	1,360,349.6	180,069.4	115.3
6	Үйл ажиллагааны бус зардал	299,763.0	613,883.7	314,120.7	204.8
7	Нийт орлого	86,262,846.4	71,126,100.5	4,863,254.1	107.3
8	Нийт зардал	89,435,784.3	84,879,168.8	(4,556,615.5)	94.9
9	ОНТНЗ	1.35	1.19	(0.16)	88.4
10	Татвар төлөхийн өмнөх алдагдал	(23,172,937.9)	(13,753,068.3)	9,419,869.6	59.3
11	Орлогын татварын зардал	184,322.9	32,348.1	(151,973.8)	17.6
12	Тайлант үеийн цэвэр алдагдал	(23,357,260.80)	(13,785,417.5)	9,571,843.3	59.0
13	Авлага	7,275,342.30	15,839,121.90	8,563,779.6	217.7
14	Нийт өр төлбөр	2,384,117.70	1,976,050.07	(408,067.6)	82.9
15	Хөрөнгө оруулалт	11,347,090.00	5,980,455.83	(5,366,634.2)	52.7
16	Орон тоо	1892	1816	(76)	96.0

Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйцээг аккруал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилууллын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдл

Төлөвлөлтөйн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дүнд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоос.

Төлөвлөлтөйн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 92,610,786.4 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 1,389,161.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтөйн материаллаг байдлын 75 хувиар буюу 1,041,871.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтөйн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4. Санхүүгийн тайлангийн тодруулга

4.1 Байгууллагын үйл ажиллагаа

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар гэсэн статустай байна. Өмчийн 100.0 хувийг төр, Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын өмчлөгч нь НИТХ байх бөгөөд төлөөлөл хэрэгжүүлэгч нь НИТХ болон Засаг даргаас олгосон эрхийн хүрээнд НӨАУГ байна.

Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг "Нийслэлийн хүн ам, албан байгууллагуудад стандартын шаардлага хангасан цэвэр усаар тасралтгүй хангах, бохирдсон усыг зохих стандартын дагуу цэвэрлэж зайлуулах, хэрэглэгчдийн усны алдагдлыг бууруулах, усны бохирдолтын хэмжээнд хяналт тавих, усны эх үүсвэр, нөөцийг хамгаалахад чиглэсэн үйл ажиллагаа явуулах, цэвэр бохир усанд лабораторийн шинжилгээ хийж хяналт тавих, эзэмшилтийн инженерийн шугам, сүлжээ, тоноглолд технологийн шинэчлэлт хийж" гэж тодорхойлсон байна.

Нийслэлийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хүрээнд 2021 онд "Чадварлаг хүний нөөц, байгальд ээлтэй дэвшилтэт технологийр ус хангамж, аргутах татууртын үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэж, хөгжилд тэмүүлсэн манлайлагч байгууллага болно" гэсэн эрхэм зорилго тавин, 57 арга хэмжээ төлөвлөснөөс 97.5 хувийн хэрэгжилттэй ажилласан байна.

4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоол;
- Монгол Улсын Засгийн газрын 2021 оны "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам" 160 дугаар тогтоол
- Монгол Улсын Засгийн газрын 2021 оны "Коронавируст халдвар (Ковид-19)-ын тархалтын түвшинг тогтоож, төрийн байгууллага, хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам"

4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Санхүүгийн байдлын, санхүүгийн үр дүнгийн, мөнгөн гүйцээний, өмчийн өөрчлөлтийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/Мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	22,896,347.0	13,566,501.0	(9,329,846.0)
Авлага	9,571,720.4	23,812,653.7	14,240,933.3
Урьдчилгаа	458,861.0	222,525.3	(236,335.7)
Бараа материал	10,200,734.7	7,745,871.0	(2,454,863.7)
Үндсэн хөрөнгө	365,200,793.0	429,847,887.3	64,647,094.3
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	408,328,466.2	475,195,438.3	66,866,982.1
Болно хугацаат өр төлбөр	7,300,141.6	1,426,439.1	(5,873,702.5)
Урт хугацаат өр төлбөр	204,411,473.6	549,610.9	(203,861,862.6)
Өмч:	874,877.6	874,877.6	0.0
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	111,938,139.6	111,938,139.6	0.0
Эздийн өмчийн бусад хэсэг	289,418,158.7	435,536,008.9	146,117,850.2
Хуримтлагдсан ашиг	(205,614,334.7)	(75,129,637.8)	130,484,697.0
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	408,328,466.2	475,195,438.3	66,866,982.1

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилж гарсан зардал, бараа материал, үндсэн хөрөнгө, болно болон урт хугацаат өр төлбөр, эздийн өмч, хуримтлагдсан үр дүнгийн данснуудад материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 13,566,501.0 мянган төгрөг болж 9,329,846.0 мянган төгрөгөөр буурахад Ковид-19 цар тахлын улмаас борлуулалтын орлого буурсан нь шалтгаалжээ.

Авлага дансны үлдэгдэл 23,812,653.7 мянган төгрөг болж 14,240,933.3 мянган төгрөгөөр өссөн нь МУЗГ-ын 2020 оны 211 дүгээр тогтоолоор айл өрхийн болон зарим аж ахуйн нэгж, байгууллагын цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөрийг төрөөс хариуцах болсонтой холбоотойгоор 2021 оны 9 дүгээр сарын хагасаас 12 сарыг дуустал хугацааны усны авлага орж ирээгүй нь гол нөлөө үзүүлсэн байна. Үүнээс гадна татвар, нийгмийн даатгалын авлага 280,580.7 мянган төгрөгөөр өссөн нь НӨАТ-ын тухай хуулийн дагуу үндсэн хөрөнгө, тоног төхөөрөмж авахад төлсөн татварыг хувь тэнцүүлэн авахаар тооцсонтой холбогдуулан үүссэн байна.

Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын Удирдах зөвлөлийн 2009 оны тогтоолоор найдваргүй авлагын нөөцийг авлагын эцсийн үлдэгдлийн 3-5 хувиар байгуулахаар тогтсон бөгөөд тайлант онд 335,362.6 мянган төгрөгийн авлагыг найдваргүй авлагаар бүртгэж, авлагын эцсийн дүнгээс 3.0 хувиар тооцон, 709.2 сая төгрөгөөр найдваргүй авлагын хасагдуулаа дансыг нэмэгдүүлсэн байна.

Урьдчилж төлсөн зардал данс нь 222,525.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаагаас Засвар үйлчилгээний программын урьдчилгаа 291,100.0 мянга, Эрэлтийг нэмэгдүүлэх зөвлөх үйлчилгээний урьдчилгаа 18,000.0 мянга, Үйлчилгээний хэсгийн шатахууны картын үлдэгдэл 30,100.0 мянга, Налайхын замын ажлын барьцааны авлага 48,400.0 мянга, мөн

Их засварын болон шугам доторлогооны төслийн ажлуудын урьдчилгаа 96,925.3 мянган төгрөгийн үлдэгдлээс тус тус бүрдсэн байна.

Бараа материал тайлант онд худалдан авсан 16,797,432.5 мянган төгрөгөөр нэмэгдэж, зарцуулсан 19,252,296.2 мянган төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгийн данс улс, нийслэлийн хөрөнгө оруулалт, төсөл, хандив тусламжаар үнэ төлбөргүй шилжих ирсэн 79,260,662.0 мянга, өөрийн хөрөнгөөр их засвар, хөрөнгө оруулалтын хүрээнд худалдан авсан 7,868,664.8 мянга, биет бус хөрөнгөөс шилжих ирсэн 699.9 мянга, нийт 87,130,026.6 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, НӨАУГ-ын шийдвэрээр акталсан 2,170,191.0 мянган төгрөгөөр буурсан.

Биет бус хөрөнгө тайлант онд өөрийн хөрөнгөөр программын сайжруулалт 462,120.4 мянга, улс, нийслэлийн хөрөнгө оруулалт, хандив тусламжаар үнэ төлбөргүйгээр бүртгэсэн 1,305,735.2 мянга, нийт 1,767,855.6 мянган төгрөгөөр нэмэгдэж, НӨАУГ-ын шийдвэрээр акталсан 37,624.1 мянга, үндсэн хөрөнгийн данс руу шилжсэн 699.9 мянга, нийт 38,324.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 1,426,439.1 мянган төгрөг нь хөрөнгө оруулалтын ажлын барьцааны өглөг 506,742.2 мянга, хэмжүүр баталгаажуулалтын өглөг 13,120.0 мянга, шатахууны болон бусад өглөг 52,953.1 мянга, ААНОАТ болон НӨАТ-ын өглөг 27,967.8 мянга, ажиллагаатай холбоотой УТБ-ны түгээгч, усны машины жолооч нарын барьцааны өглөг 43,028.9 мянга, хэрэглэгчдээс урьдчилж төлсөн усны орлого 782,627.1 мянган төгрөгөөс тус тус бүрдсэн.

Урт хугацаат өр төлбөр 208,777,886.5 мянган төгрөгөөр буурсан нь урт хугацаат өрийг шилжүүлэх тухай 3Т-ын 2021 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 26 дугаар тогтоол, НЗД-ын 2021 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн А/198 дугаар захирамжийг үндэслэн урт хугацаат зээлийн хүүгийн өглөг 4,916,023.9 мянга, зээлийн өрийн үлдэгдэл 204,411,473.6 мянган төгрөгийг НӨАУГ-т балансаас баланст шилжүүлсэн байна. Тайлант хугацааны урт хугацаат зээлийн үлдэгдэл нь 1-ээс дээш жилийн хугацаатай хөрөнгө оруулалтын ажлуудын барьцааны 5.0 хувийн үлдэгдэл 549,610.9 мянган төгрөг байна.

Эздийн өмчийн бусад хэсэг дансны үлдэгдэл 435,536,008.8 мянган төгрөг болж 146,117,850.2 мянган төгрөгөөр өсөхөд НЗД-ын А/198 дугаар захирамжийг үндэслэн зээлийн анхны түүхэн өртгийн дүнгээр НӨАУГ-ын балансаас баланст шилжүүлсэн 64,185,600.0 мянга, улс, нийслэлийн хөрөнгө оруулалтаар 49,736,600.0 мянга, буцалтгүй тусламж хандиваар 8,979,700.0 мянга, төсөл, арга хэмжээгээр 23,215,950.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь шалтгаалжээ.

Хуримтлагдсан ашиг (алдагдал) дансны үлдэгдэл 75,129,637.8 мянган төгрөг болж 130,484,697.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны алдагдал 13,785,417.4 мянга, нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт 135,201.9 мянга, НЗД-ын А/198 дугаар захирамжийг үндэслэн зээл, зээлийн хүүгийн үлдэгдэл (зээлийн хүүгийн зардал, валютын ханшийн зөрүүгийн бодит бус ашиг, алдагдал)-ийг НӨАУГ-ын балансаас баланст шилжүүлсэн 144,134,912.5 мянган төгрөгөөр бууруулснаас тус тус шалтгаалжээ.

4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу Ус сувгийн улирдах газар ОНӨААТҮГ-ын дарга нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Нийслэлийн Засаг даргын 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 02/2021 дугаартай "Ус сувгийн удирдах газар орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захиралтай байгуулсан контракт"-ын дагуу 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө баталсан байна.

Тайлант оны нийт орлогыг 66,262,846.4 мянган төгрөгөөр, нийт зардлыг 89,435,784.3 мянган төгрөгөөр, алдагдлыг 23,357,260.8 мянган төгрөгөөр тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 11,142,190.0 мянган төгрөгийг төлөвлөсөн байна.

Орлогын эх үүсвэр нь цэвэр ус түгээх, бохир ус татан зайлуулах, цэвэр бохир усанд лабораторийн шинжилгээ хийх гэсэн үндсэн үйл ажиллагаанаас олсон орлого болон урлаг үйл ажиллагааны орлогоос бүрдэх бөгөөд тайлант хугацааны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг алдагдалтай баталсан нь урт хугацаат зээлийн дансанд гадаад валютын зээлийн үлдэгдэл, хүүгийн өглөгт ханшийн тэгшитгэлийг бүртгэдэгтэй холбоотой.

Гүйцэтгэлээр 71,126,100.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 84,879,168.8 мянган төгрөгийн зардал гарган, 13,785,417.5 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Хүснэгт 2. 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

/ мянган төгрөгөөр /

№	Үзүүлэлт	2021 оны		Хувь
		Гүйцэтгэл	Төлөвлөгөө	
1	Үндэрсэлтийн үндсэн үзүүлэлт	44,322.0	44,322.0	
		Борлуулах ус	44,322.0	44,322.0
2	Нийт орлого	66,112,768.6	66,262,846.4	107.9%
		Үүнээс: Цэвэр борлуулалт	63,223,129.5	65,082,566.2
3	Нийт зардал	84,879,168.8	84,879,168.8	94.9%
		Үүнээс:		
	а) Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	74,534,210.5	85,813,374.6	94.8%
	б) Ерөнхий ба удирдлагын зардал	9,656,501.1	3,322,646.7	86.5%
	в) Хөрөнгө оруулалт-их засвар	8,896,737.0	11,347,090.0	48.3%
4	Цэвэр ашиг, алдагдал	(27,005,066.1)	(23,357,260.8)	95.0%

Нийт орлогын гүйцэтгэл 71,126,100.5 мянган төгрөг болж төлөвлөснөөс 4,863,254.1 мянган төгрөгөөр буюу 7.3 хувиар давуулан биелүүлсэн нь авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулсан, УТБ-уудад ухаалаг цахим карт нэвтрүүлж, хэрэглэгчдэд өргөн сурталчилж, түгээн борлуулсантай холбоотой байна.

Нийт зардлын гүйцэтгэл 84,879,168.8 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 4,566,615.5 мянган төгрөгөөр буюу 5.1 хувиар хэмнэлттэй ажилласан байна. Энэ нь Ковид-19 цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалж бараа материалын хомсдол үүссэнээс зарим ажил, худалдан авалтуудад төлөвлөсөн хөрөнгө хүрэлцэхгүй болсон, МУЗГ-ын 43 дугаар тогтоолын дагуу төслийн хэмнэлтийн горимд шилжсэнээр 2021 онд ашигдалтад оруулахаар төлөвлөж байсан хөрөнгө оруулалтын ажлууд хийгдээгүйгээс цалингийн зардал, элэгдлийн зардал, ашиглалтын зардал, бодисын зардлыг дутуу зарцуулсан нь гол нөлөө үзүүлсэн байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу улс, нийслэлийн төсвөөс 544,300.0 мянга, төсөл хөтөлбөрөөс 21,904,500.0 мянга, хандив, буцалтгүй тусламжаар 8,942,200.0 мянга, өөрийн эх үүсвэрээс 49,172,400.0 мянган төгрөгийн зардлыг тус тус санхүүжүүлсэн байна.

Тайлант онд цэвэр алдагдал 13,785,417.5 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 9,571,843.3 мянган төгрөгөөр бага байгаа нь 7.3 хувиар орлогын төлөвлөгөө биелсэнтэй холбоотой байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилгот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалтсан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 20 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалталаа.

Шилэн дансны цахим хуудсанд цалингаас бусад таван сая төгрөгөөс дээшхи орлого, зарлагын болон худалдан авалттай холбоотой нийт 143,237,749.1 мянган төгрөгийн 1551 мэдээллийг байршуулахаас 1550 мэдээллийг ил тод мэдээлж, *аудитын тайлан, дүгнэлтэд тусгаарласан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний 1 мэдээллийг цахим хуудсанд мэдээлээгүй, хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төслийн 1 мэдээлэл, төсөв өмч хөрөнгө, өр аялага үүсгэсэн тухай 1 шийдвэрийг тус тус хугацаа хоцроож мэдээлсэн байна.*

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах зөвлөмж өгөв.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд Үндэслэн Төсвийн тухай хууль болон МУЗГ-ын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.6 дахь заалтуудыг хэрэгжүүлээгүйгээс 8,073.4 мянган төгрөгийн зөрчил гаргасан. Үүнд:

- 1.6 "Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэрэгдэ зохион байгуулахгүй байх" заалтыг зөрчин, байгууллагын 4 төрөлт тэмцээн зохион байгуулж, 8,073.4 мянган төгрөгийн зардал гаргасан;

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн жилд МУЗГ-аас бүх шатны төрийн өмчит болон төсвийн байгууллагуудад даалгасан төсвийн хөрөнгийг хэмнэх, үр ашгийг зарцуулах тухай тогтоол шийдвэрийг хэрэгжүүлж ажиллах, дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгсөн.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

6.1 Завсрын аудитын үр дүн:

2021 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар биет тест хэрэгжүүлж, үндсэн хөрөнгө болон бараа материалын үлдэгдэлд хэсэгчилсэн хяналтын тооллого хийж, ТБОНӨХБҮХАТХ-ийн хэрэгжилтийг аудитын багаараа газар дээр нь очиж шалтсан. Аудитаар нийт 545,454.0 мянган төгрөгийн 15 зөрчил илэрсэн бөгөөд засварын аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг УСУГ ОНӨААТҮГ-аас 2022 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн 4/76 дугаар тогтоор өгсөн, зөвлөмжийн биелэлт 75.0 хувьтай байна. БХУСАТ-ны барилга байууламжийн дансанд бүртгэлтэй 12 айлын орон сууцны үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ байгаа тухай зөвлөмжийн дагуу НӨАУГ-г бичиг хүргүүлсэн нь одоогийн байдлаар шийдвэрлэгдээгүй байна. Мөн БЗД-ийн 61 дүгээр цөцөрлөлт ашиглаж байгаа боловч НҮА-ны данс бүртгэлд тусгагдсан байгаа 127,505.3 мянган төгрөгийн эргэлтийн ба эргэлтийн бус хөрөнгийг шилжүүлэх тухай зөвлөмж өгсөн нь хэрэгжээгүй байна.

6.2 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 277,763.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 38,573.2 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 147,273.2 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 91,916.6 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 7 зөвлөмж өгсөн байна.

Хүснэгт 3: Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт /Мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Хувь
Төлбөрийн акт	2	38,573.2	2	38,573.2	-	100%
Албан шаардлага	1	147,273.2	1	103,091.2	-	70%
Зөвлөмж	7	91,916.6	7	91,916.6	-	100%
Нийт дүн	10	277,763.0	10	233,581.0	-	90%

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар цаг хугацаа, аудитыг гүйцэтгэж буй хүн хүчний хязгаарлагдмал байдлаас шалтгаалан гүйцэтгэж амжаагүй дараах асуудлуудыг дараагийн аудитаар авч үзэхээр тогтлоо. Үүнд:

- Тайлант хугацаанд гүйцэтгэгч байгууллагад олгосон хөрөнгө оруулалтын санхүүжилт болон бараа, ажил үйлчилгээний худалдан авалтыг татварын и-баримт цахим хуудсанд харилцагч байгууллага шивсэн эсэхэд хяналтыг хэрэгжүүлэх;
- Улс, нийслэлийн, гаднын төсөл, хандив тусламжаар болон өөрийн хөрөнгөөр хийгдэж буй барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмжийн шинэчлэлийн ажлуудыг ТБОНӨХБҮХАТХ-ийн дагуу хэрэгжүүлж байгаа эсэхэд хяналтыг хэрэгжүүлэх;

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 939,268.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 407,436.0 мянган төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 531,832.1 мянган төгрөгийн 7 зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

8.1. Албан шаардлага:

8.1.1. Санхүүгийн тайлангаарх 351,016.4 мянган төгрөгийн өр төлбөр, урьдчилж орсон орлогыг баталгаажуулаагүй, өмнөх аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6." өр хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн

нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах," заалтыг зөрчсөн.

8.1.2. Газрын даргын тушаалаар тухайн алба хэлтсийн үр дүнгийн урамшуулалт цалинг олгох дундаж хувьнаас илүү дүнгээр 1,464.8 мянган төгрөгийн урамшуулалт цалин олгосон нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4 "Төрийн өмчийн төлөөлөгч дараах эрх үүрэгтэй...3/ олгогдсон эрх хэмжээнийхээ дотор төрийн өмчийн төлөөллийг хэрэжүүлэх" заалтыг зөрчсөн байна.

8.1.3. Хүнсний материал авсан 54,954.8 мянган төгрөгийн баримтууд нь QR кодоор баталгаажуулаагүй, ажилчдын хоолны газрын тогооч материалын тайланг хоолны нэр төрлөөр тайлагнадаггүй, ажилтан албан хаагчдад өгч байгаа хоолны чанар, орд хэмжээ, норм, нэр төрлөөр бажуулагдсан "нийтийн хоолны технологийн карт" байхгүй байгаа нь НӨАТ-ын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.14. "төлбөрийн баримт" гэж тухайн төлбөр тооцоо хийгдсэнийг нотлох он, сар, өдөр, дахин даатагдахгүй төлбөрийн дугаар бүхий нэгдсэн системээр баталгаажсан, албан татвар суутгаан төлөөх буюу худалдаа эрхлэгчид ганцхон тэмдэг бүхий нэр, хаяг, татвар төлөгчийн дугаар, худалдаа хийгдсэн бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, төлбөр тооцооны болон татварын дүн зэрэг мэдээллийг агуулсан зориулалтын тоноо төхөөрөмжөөс гаргасан цаасан болон цахим баримтаа, Хүнсний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 "хүнсний чанар" гэж хүнсний түүхий эд бүтээгдэхүүний стандарт, техникийн зохицуулалтын болон хэрэглээний шаардлага хангасан байдлыг," заалтуудыг зөрчсөн.

8.2. Зөвлөмж:

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдоллын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

8.2.1 Балансын данстай холбоотой асуудал:

1.1. Илрүүлэлт: Тус байгууллага нь үйлдвэрлэлийн 6 алба, зохимон байгуулалтын 16 нэгж хэлтсүүдийн санхүүгийн тайлан балансыг үндэслэн, байгуулалтын хэмжээнд нэгтгэсэн санхүүгийн баланс гаргадаг. Нэгжээс ирж байгаа тайлангийн салбар хоорондын тооцооны данс нь хаагдахгүй "санхүүгийн бусад хөрөнгө" гэсэн "хасагдах утга"-гүй дансанд хасах тэмдэгтэйгээр тайлагнаснаас үүдэн нэгжийн нийт хөрөнгө, нийт өр төлбөр, эздийн өмч нь хасах тэмдэгтэй тайлагнагдаж байна нь МУ-ын Сангийн сайдын 2017 оны 361 дугаар тушаалаар баталсан "Маягт, заавар батлах тухай" журмын 1.Аж ахуйн нэгж нь нийтлэг зориулалттай тусдаа санхүүгийн тайланг бэлтгэхэд энэ зааврыг мөрдөнө. 5.Санхүүгийн тайлан, тодруулгын хасагдах утгатай дүнг хасах тэмдэгтэйгээр оруулалттай тухайн тайлангийн зорилт 1.Санхүүгийн тайлан нь гаднын болон долоодын хэрэглэгчид эдийн засгийн шийдвэр гаргахад нь шаардагдах тухайн байгууллагын санхүүгийн байдал (хөрөнгө, эздийн өмч, өр төлбөр), санхүүгийн үр дүн (орлого, үр дүн), санхүүгийн байдалд гарсан өөрчлөлт (мөнгөн гүйлгээний) –ийн талаарх мэдээллээр хангана. 2.Санхүүгийн тайланг хугацаанд нь үнэн зөв гаргах үүрэг, харууллаагүй аж ахуйн нэгжийн удирдлага хүлээнэ." заалтуудтай нийцэхгүй. Санхүүгийн тайлангийн тодруулга ба толилуулга, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2.Өгсөн зөвлөмж: Нэгж дээрх санхүүгийн байдлын тайлангаарх "бусад санхүүгийн хөрөнгө" дансыг салбар хоорондын ажил гүйлгээ хийгдэж байгаагаас хамааран "хоорондын тооцооны данс" гэсэн нэршлэр нь тайлагнах, МУ-ын Сангийн сайдын 2017 оны 361 дугаар тушаалын хавсралт 1 "Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын хэрэгжилтийг хангаж ажиллах;

8.2.2 Тайлааналт холбоотой асуудал:

2.1 Илрүүлэлт: Өмнөх оны ажлын үр дүнг үнэлсэн үр дүнгийн урамшуулалт цалин 471,253.3 мянган төгрөгийн зардлыг дараа оны цалингийн зардалд тайлагнасан нь Нягтлан бодох

бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 "Аж ахуйн нэгж нь нягтлан бодох бүртгэлээ аккрузл сууриар хөтөлнө", 3 дугаар зүйлийн 3.1.1 "нягтлан бодох бүртгэлийн аккрузл суурь гэж мөнгө хүлээн авсан, эсхүл төлсөн эсэхээс хамаарахуудгаар орлогыг олсон үед, зардлыг гарсан үед нь хүлээн зөвшөөрч бүртгэх аргыг" заалтуудтай нийцэхгүй, эрх ба үүрэг, үнэн зөв байдал, толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2.Өгсөн зөвлөмж: Тайланг оны цалингийн зардлыг хүлээгдэж буй гүйцэтгэлээр гаргаж ондоо багтан зардлаар хүлээн зөвшөөрч тайлагнах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлж ажиллах;

8.2.3 Балансын данстай холбоотой асуудал:

3.1.Илрүүлэлт: Кассын тайланг журмын дагуу бэлтгэж архивын нэгж болгоогүй, нэгдсэн баланстай үдсэн, төв касс нь бэлэн мөнгөний орлогын баримт, төлбөрийн хэвлэл баримтуудыг бусад баримтын хамт үдээгүй, кассын зарлагын баримттай хамт нааж, дугааруулаагүй, алба хэлтсүүдийн жижиг мөнгөн сангийн сар бүрийн кассын үлдэгдэл нийт 44,054.8 мянган төгрөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зэрэг нийтлэг зөрчил байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.4 "мөнгөн хөрөнгө, шалгах, тослох материал болон жижиглэн худалдаалах газар байгаа бараа, сав, боослыг сар бүр сар бүрийн 1-нээр," заалтыг хэрэгжүүлээгүй.

3.2.Өгсөн зөвлөмж: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.4 заалтыг хэрэгжүүлж ажиллах, мөнгөн хөрөнгийн дансны бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах;

8.2.4 Балансын данстай холбоотой асуудал:

4.1.Илрүүлэлт: Үйлдвэрлэлийн нэгж болох ШАЗА-ны үндсэн хөрөнгийг түүврээр үзэхэд хуримтлагдсан элэгдлээ бүрэн байгуулсан, дахин үнэлж, элэгдэл тооцогдоогүй, ашиглаж байгаа 343,597 тооны 5,921,409.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт-16, ТБОНӨТХ-ийн 31 дүгээр зүйлийн 31.2 "илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтлэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох" заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

4.2.Өгсөн зөвлөмж: Ашиглалтын хугацаа дууссан хөрөнгийн судалгааг гарган холбогдох байгууллагад асуудлыг тавьж, хөрөнгийг дахин үнэлж, данс бүртгэлд тусгах, элэгдлийн зардлыг бодитоор тайлагнах;

8.2.5 Балансын данстай холбоотой асуудал:

5.1.Илрүүлэлт: Цалин хөлсний анхан шатны баримтыг тулган шалгахад, ажилчдын амралтын цалингийн мэдэгдэх хуудас, амралтын цалингийн тооцоолол зарим саруудад байхгүй, жагсаалтаар авч байгаа 16,524.0 мянган төгрөгийн суутгалыг ажилчдад танилцуулсан гарын үсэг дутуу зэрэг зөрчил байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1. "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтөлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" заалтыг зөрчсөн.

5.2.Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах, бүртгэлд тавих хяналтыг сайжруулах;

8.2.6 Балансын данстай холбоотой асуудал:

6.1.Илрүүлэлт: Ординат ХХК-тай 24,000.0 мянган төгрөгийн гэрээ байгуулан одоогийн хэрэглэж байгаа юникус программын хөгжүүлэлт хийсэн боловч нэгдсэн тайлангийн өрөнхий журнал, гүйлгээ баланс, бараа материал, үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайлан байхгүйгээс гадна алба хэлтсийн тайлангуудад хасагдах утга-гүй данс /санхүүгийн бусад

хөрөнөө/ хасах тэмдэгтэй актив талд тайлагнагдсанаас тухайн нэгж нь хасах нийт хөрөнгө, нийт өр төлбөртэй байгаа зэргийг программын түвшинд сайжруулаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "Төсвийг үр ашгатай хэмнэлттэй байхаар төлөвөлж, зарцуулах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.1 "... үр ашгатай зохион байгуулах үр чөлөөтэй, хувийн өмчлөлт хуулийн этгээд, хувь хүнээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно." заалтуудыг хэрэгжүүлээгүй.

6.2 Өзгөн зөвлөмж: Төсвийг үр ашгатай, хэмнэлттэй зарцуулах, нэгтгэсэн санхүүгийн тайлангийн ерөнхий журнал, бусад дэлгэрэнгүй журналуудыг программын түвшинд нэгтгэж тайлагнадаг болох;

8.2.7 Балансын данстай холбоотой асуудал:

7.1 Илрүллэлт: Бараа материалын тайлангийн орлогын болон зарлагын баримт дээр авсан, өгсөн ажилтнуудын гарын үсэг байхгүй, шаардах, орлогын баримтын огнооноос зөрүүтэй, хавсаргасан баримтууд нь тамга тэмдэггүй, гарын үсэг дууу, засварын ажлуудын ажлын тайлан байхгүй зэрэг нийтлэг зөрчлүүд байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1. "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно." заалтыг хэрэгжүүлээгүй.

7.2 Өзгөн зөвлөмж: Бүртгэлд тавих хяналтыг сайжруулах, бараа материалын тайлангийн холбогдох анхан шатны баримтын бүрдүүлэлтийг хангаж ажиллах;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлэе.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Д/д	Алдаа, зөрчлийн товч утга		Санхүүгийн тайлангийн аудитын асуудал:			
	Товч	Дүн	Нийт алдаа, зөрчлийн	Заруулга	Төсвийн акт	Албан шаардлага
1	Санхүүгийн тайлангаарх өр төлбөр, урьдчилж орсон орлогыг баталгаажуулаагүй.	351,016.4	1	351,016.4	1	351,016.4
2	Гэрчлэл дараа хувиас илүү хувийн урамшуулалт цалинг	1,464.8	1	1,464.8	1	1,464.8
3	Хүнсний материал авсан баримтууд нь QR кодоор баталгаажуулаагүй, ажилчдын хоолны газрын тосгоо мөнгөний тайланг хоолны нар төрлөөр тайлагнадаггүй, ажилтан	54,954.8	1	54,954.8	1	54,954.8
4	Үндэслэлгүйн нэг болох ША3А-ны үндсэн хөрөнгийг түрээр үзэхэд хүртээгдэсэн эзлэх бүрэн байгуулсан, дахин үнэлүүлсэн үндсэн тооцоогүй, ашиглаж байгаа 5,921,409.2 мянган төрлийн үндсэн	-	1	-	1	-
5	Ординат ХХК-тай 24.00 мянган төрлийн гэрээ байгуулан одоогийн хэрэгжээж байгаа юуныуц программын хөгжүүлэлт хийсэн боловч нэгдсэн тайлангийн ерөнхий журнал, үйлдэс багана, бараа материал, үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайлан байхгүйгээс гадна алба хэмтэй тайлангуудад хасагдах утга-гүй данс/санхүүгийн бусад хөрөнгө, хөнгөлөлтөтэй актив талд тайлагнагдсанас тухайн нэгж нь хасах нийт хөрөнгө, нийт өр төлбөртэй байгаа зэргийг программын түвшинд заруулж, сайжруулаагүй байна.	-	1	-	1	-
6	Ажилчдын амралтын цалингийн мэдэгдэх хуудас, амралтын цалингийн тооцоолол гарын үсэг агуу.	16,524.0	1	16,524.0	1	16,524.0
7	Үндсэн төлбөр журмын дагуу бэлтгэж архивын нэгж болгоогүй, нэгдсэн байнгын үйлдэс баримтын хамт үзэггүй, кассын зарлагын баримтын хэвлэмэл баримтуудгүй, кассын тайланг журмын дагуу бэлтгэж архивын нэгж болгоогүй, нэгдсэн байнгын үйлдэс актээр баталгаажуулаагүй.	44,054.8	1	44,054.8	1	44,054.8

Санхүүгийн тайлангийн аудитын агуулга:										
Дүн										
	10	9	8	7	6	5	4	3	2	1
8	1	-	-	-	-	-	-	-	-	-
9	1	471,253.3	-	-	-	-	-	-	-	-
10	1	-	-	-	-	-	-	-	-	-
Баруун дундговь аймгийн орлогын болон зарлагын баримт дээр авсан, өрсөн ажиглалтын тухай тайлан байхгүй, шаардах, орлогын баримтын онооноос зөрүүлэн, хавсаргасан баримтууд нь тайла тэмдэглэж, гарын үсэг дутуу, засварын ажиглалтын ажлын тайлан байхгүй.										
9	1	471,253.3	-	-	-	-	-	-	-	-
Өмнөх оны ажлын үр дүнг үнэлсэн үр дүнийг урьмшуулалт цалин дараа оны цалингийн зардалд тайлагнасан.										
10	1	-	-	-	-	-	-	-	-	-
Нэгжийн санхүүгийн тайлан баянсыг үндэслэн, байгууллагын хэмжээнд нэгтгэсэн санхүүгийн баримт гаргадаг утга-гүй дансанд хасах тэмдэгтээр тайлагнаснаас үүдэн нэгжийн нийт хөрөнгө, нийт өр төлбөр, эзэмчлэл нь хасах тэмдэгтэй тайлагнагдаж байна.										
2	1	-	-	-	-	-	-	-	-	-
Шилэн дансны цахим хуульчилж 143,237,749.1 мянган төгрөгийн 1551 мэдээллийг баруундговь аймагт мэдээллийг хураацаа хоцроож мэдээлсэн.										
1	1	8,073.4	-	-	-	-	-	-	-	-
Тайлант онд 31-ын тогтоолыг зөрчиж байгууллагын 4 төгрөгт тэмцээнийг зохион байгуулсан.										
2	2	8,073.4	-	-	-	-	-	-	-	-
Дүн										
12	12	947,341.5	-	-	-	-	-	-	-	-
8	8	415,509.4	-	-	-	-	-	-	-	-
Нийт дүн										
8	8	531,832.1	-	-	-	-	-	-	-	-

ХТМ-2022/46/НА-СА-ОНААН 20